



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/420

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5/а/, 29.2, Монгол улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.2, 26 дугаар зүйлийн 26.2, 26.5, Эрүүл мэндийн тухай хуулийн 11.1.1, 11.1.2, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 340 дүгээр тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн III хуралдааны 01 дүгээр тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн VI хуралдааны 02 дугаар тогтоол, 2017 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 6/02, 6/04, 6/05 дугаар тогтоолуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Эмч”, “Багш”, “Ач санах” дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн ахмад настан /65-70 настай/, эрүүл мэнд, боловсролын салбарын ажиллагсадыг /40-өөс дээш настай/ эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах арга хэмжээний зардлыг хавсралтаар баталж, “Медипас” эмнэлэгтэй 2017 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс хамтран ажиллах гэрээ байгуулан гүйцэтгүүлсүгэй.

2. Шаардагдах 70380000 /Далан сая гурван зуун наян мянган/ төгрөгийн аймгийн Засаг даргын 2017 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн “Хуваарилалт хийх тухай” А/306 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан “Эрүүл мэндийн салбарын ажиллагсадыг /40-өөс дээш настай/ эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах арга хэмжээний зардал”-аас 21000000 төгрөг, 4 дүгээр хавсралт хавсралт “ Ахмад настануудыг /65-70 нас/ эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах арга хэмжээний зардал”-аас 20 000 000 төгрөг, 3 дугаар хавсралтын “Боловсролын салбарын ажиллагсадыг /40-өөс дээш настай/ эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах арга хэмжээний зардал”, 20 000 000 төгрөг, “Нийгмийн дэмжлэгийн сан байгуулах журам боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг ханган ажиллах зардал”-аас 9 380 000 төгрөгийг тус тус гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, Төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж, үр дүнг тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга А.Бумансорд даалгасугай.

4. Ахмад настанууд, эрүүл мэнд, боловсролын салбарын ажиллагсадыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах арга хэмжээг төлөвлөгөө, үзлэгийн хуваарь гарган зохион байгуулж, үр дүнг тайлагнаж ажиллахыг Эрүүл мэндийн газар /н.Баттүвшин/, Боловсрол, соёл урлагийн газар /н.Бат-Амгалан/, аймгийн Ахмадын хороо /н.Амаржаргал/ нарт тус тус үүрэг болгосугай.



Д.БАТЛУТ

D:(Zahiramj) A-4 doc
0200001915

Аймгийн Засаг даргын 2017 оны
07 дугаар сарын 27-ны өдрийн
420 захирамжийн хавсралт

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗЛЭГ, ШИНЖИЛГЭЭНД ХАМРУУЛАХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хүний тоо	Нэг хүний зардал	Бүгд	Орон нутгийн төсвөөс гаргах	Тайлбар
1	Ахмад настан /65-70 настай/	1000	40000	40000000	20000000	50 хувийг хувь хүн гаргах
2	Эрүүл мэндийн салбарын 40 дээш настай ажиллагсад	525	40000	21000000	21000000	
3	Боловсролын салбарын 40 дээш настай ажиллагсад	1469	40000	58760000	29380000	50 хувийг хувь хүн гаргах
	Нийт	2994		119760	70380000	49380000